

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ӨГӨХ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

2021 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөлөлтэй уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалтын дагуу Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, нийслэл, сум, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсыг хөгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

УИХ-ын 2017 оны 83-р тогтоолоор баталсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн 3.1.1 дэх заалтад тусгагдсан бүрэн эрхийн хүрээнд тус Зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдөр өргөн барьсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах” тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй танилцсаны үндсэн дээр дор дурдсан дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Монгол Улсыг хөгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтын дагуу анх удаа шинээр боловсруулж байгаа хөгжлийн бодлогын зорилт бичиг ажээ. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн уг төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрийн “бодлогын үндэслэл”-ийг Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний холбогдох заалт бүртэй холбон гаргасан байна (Хавсралт 1).

УИХ Монгол Улсын 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөлөлд төсвийн зарлагыг 14.8 их наяд төгрөг буюу ДНБ-ний 32.5 хувь, төсвийн алдагдлыг -1.6 их наяд төгрөг буюу ДНБ-ний -3.6 хувь байхаар баталсан. Түүнчлэн Монгол улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдлээр улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2022 онд 13.2 их наяд төгрөгт хүрэхээр байгаа нь 2021 оны батлагдсан дүнгээс 1.4 их наяд төгрөгөөр буюу 12 хувиар өсөхөөр тооцсоныг харуулж байна. Харин Монголбанкны суурь төсөөллөөр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 12.7 их наяд төгрөгт хүрэхээр байгаа нь ТХМ-д тусгасан орлогоос 500 орчим тэрбум төгрөгөөр бага байна. Нөгөө талаас цар тахлын эрсдэл буураагүй, эдийн засгийн идэвхжил бэхжээгүй, уул уурхайгаас бусад салбарын өсөлт эмзэг байгаа үед төсвийн орлогын төсөөлөл хэт өөдрөг байж болзошгүй юм. Иймд Монгол улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг бүхэлд нь хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал гэж үзэж болохоор байгаа тул анхааралдаа авах нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг хэлэлцэж, батлахдаа дараах зүйлд анхаарахыг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Коронавируст халдвар (Ковид-19) улс орныг улам хамарч, эдийн засгийн байдалд ноцтойгоор нөлөөлж байна. Цаашид төсвийн орлого буурч, 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд заасан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө хүрэлцэхгүй байх эрсдэл үүсэхээр байгааг анхаарч үзэх ёстой.

2. Иймээс төлөвлөгөөний төсөлд тусгагдсан 263 зорилт, арга хэмжээг эдийн засаг, нийгэмд үзүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж, хэрэгжүүлэх нь цар тахлын сөрөг нөлөө арилаагүй үед төсвийн үр ашигтай зарцуулалтыг нэмэгдүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөг сайжруулна.

3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (ХБТТУТХ)-ийн 4.1.11-т заасны дагуу “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг юм. Гэтэл улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 263 зорилт, арга хэмжээний 14.4 хувийнх нь санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, харин 17.9 хувийнх нь хөрөнгийн хэмжээг тусгаагүй байгаа нь анхаарал татаж байна (Хавсралт 2).

4. Цар тахлыг даван туулах (1.1), боловсрол (2.3), санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах (3.1), цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлага (4.1), төрийн байгууллагуудын үйл ажиллагааг оновчтой болгох (4.2)-той холбоотой зорилт, арга хэмжээнүүдийн 25-аас дээш хувийнх нь санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгийн хэмжээ тодорхойгүй байгаа юм. Иймд санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулах хөрөнгийн хэмжээ нь тодорхойгүй байгаа зорилт, арга хэмжээ тус бүрийн 2022 онд шаардлагатай хөрөнгийн тооцоог хийж, тусгасны дараа батлах нь зүйтэй.

5. Монгол улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 10.0 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдахаас улсын төсвийн хөрөнгөөр 870.4 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 111.7 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламжаар 2.2 их наяд төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар 1.2 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээс 5.7 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөлд тусгасан байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилтийн 57.0 хувийг бусад эх үүсвэр эзэлж байгаа бөгөөд үүнд Эрүүл мэндийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Концесс, төр хувийн хэвшлийн түншлэл, компани, аж ахуйн нэгжийн санхүүжилт, хандив, тусламж зэргээс эх үүсвэр хамаарч байна. Иймд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэх бусад гэсэн эх үүсвэрийг илүү тодорхой болгох шаардлагатай.

6. Хөгжлийн төлөвлөгөөг ЗГҮАХ-тэй уялдуулан 6 бүлэг, 23 зорилтын хүрээнд бүлэглэж, Улсын төсвийн хөрөнгөөр 870.4 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр тооцсон хэдий ч энэ санхүүжилт төсвийн хөрөнгө оруулалтын болон урсгал зардлын хэдэн хувийг эзлэх нь тодорхойгүй байна. Энэ бүхэнд дүгнэлт хийж үзэхийн зэрэгцээ хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, бодлогын арга хэмжээ гэх байдлаар дотор нь илүү тодорхой ангилах саналтай байна.

7. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн баталгаа нь 2022 оны жилийн төсөв болох ёстой¹. Иймээс уг төлөвлөгөөнд тулгуурлан тухайн жилийн төсвийн хязгаар, түүний дотор урсгал болон хөрөнгийн зардлын хэмжээг тогтоох хэрэгтэй болно гэсэн үг. Гэтэл ТХМ, төсвийн хязгаар батлах, төсвийн төсөл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулах, хэлэлцэн батлах цаглабар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай Монгол улсын хуульд хоорондоо нийцэлгүй, зөрүүтэй тогтоогдсон байна. Энэ нь улс, орон нутгийн шийдвэр гаргагчдад төдийгүй төсвийн захирагч нарт эргэлзээтэй (түвэгтэй) байдал үүсгэж буйг УИХ-ын холбогдох Байнгын хороод анхааралдаа авч нэн даруй шийдвэрлэх нь зүйтэй.

8. Үүнээс гадна улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний үндэс болох ёстой² бөгөөд “орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна” гэж ХБТТУТХ-ийн 6.10.4 дэх заалтад тусгасан юм. Эндээс сум, дүүргийн төсөв нь сум, дүүргийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байхаар харагдаж байгаа хэдий ч ХБТТУТХ-д сум, дүүргийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулах заалт тусгагдаагүй байна. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төсвийн бүх байгууллагын 60 орчим хувь нь сум, дүүргийн түвшинд ажиллаж төрийн болон нийгмийн үйлчилгээг хүргэж буй тул Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай Монгол улсын хууль, бусад хууль тогтоомжийн нийцлийг хангах шаардлага тулгарч байна.

9. Төлөвлөгөөний үр дүнгийн суурь болон зорилтот түвшинг хэт ерөнхий тусгасан байгааг илүү нарийвчлах, хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудыг тодорхой болгох, уялдаа холбоог хангахад анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

10. Төсвийн тогтвортой байдлыг хангах гол нөхцөл нь ажлын байрыг нэмэгдүүлэх, Монгол улсын хөгжлийн суурь болох салбаруудыг хөгжүүлэх явдал тул дараах арга хэмжээг улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд нэмж тусгахыг санал болгож байна. Үүнд:

- Экспортын³ үйлдвэрлэлийг дэмжих даатгал, зээлийн баталгаа, татвар, зээлийн хөнгөлөлт санхүүжилтийн хэрэгсэл зэргийг хамарсан иж бүрэн механизм бүрдүүлж хэрэгжүүлсэн байх (*Сангийн яам, Монголбанк, Гадаад харилцааны яам*).
- ОХУ тэргүүтэй Евро-Азийн Холбоо, түүний гишүүн орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээг дуусгаж байгуулсан байх (*Шадар сайд, Гадаад харилцааны яам*).

¹ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3 дахь заалтад “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж тусгасан.

² “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг хэлнэ (ХБТТУТХ-ийн 4.1.12 дахь заалт).


³ Ард түмний үнэмлэхүй олны санал авсан төрийн тэргүүний баялагтаа эзэн, импортоос экспортод гэсэн уриаг хэрэгжүүлэх учиртай. Монгол улсын хувьд хөгжлийн үндсэн гарц, ажлын байрны хангамж, гадаад өр зээлийн хүндрэлийг даван туулах гол хөшүүрэг болох экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдал юм. Экспортыг дэмждэг Япон, Герман, Голланд, Солонгос, Хятад зэрэг орнууд өдгөө хөгжлөөрөө дэлхийг тэргүүлж байна.

- Газрын тос дамжуулах хоолой барихыг хасаж оронд нь төмөр зам болгох. Учир нь Монголчууд өөрсдөө төмөр замаа 2-3 дахин хямд барьж чаддаг болсон, түүнд хэрэглэдэг цементээс эхлээд бараг бүх материал, хүн хүч Монголоос гаралтай нь цар тахлын өнөө үед дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний сүлжээг дэмжинэ. Төмөр зам бол мянганы бүтээн байгуулалт бөгөөд Дорнод зэрэг зүүн бүсэд малын өвс тэжээлээс эхлээд тээвэрлэх шаардлагатай шавхагдашгүй их баялаг бий төдийгүй байгалийн олон төрлийн баялаг бий. Зам дагаж хөгжил ирнэ, Чойбалсан хот төмөр замаар Оростой холбогдсон байдгийг ч бодож, тэндээс Оросоос алсдаа түүхий газрын тос авна.
- Зэс, газрын тос, газрын ховор элемент, сэргээгдэх эрчим хүчний судалгаа, хайгуулыг нэмэгдүүлэхэд улсын болон хувийн хэвшлийн оролцоог хангаж, дэмжиж ажиллах. Үүнд зарцуулах хөрөнгийг 50-100 сая долларт хүргэх (*Уул уурхайн сайд*). Томоохон компаниуд хайгуулд багагүй мөнгө зарцуулдаг. Манай Эрдэнэт, Рио Тинто зэрэг компаниуд хайгуулыг эрчимжүүлэхэд бэлэн байгаагаа олон удаа хэвлэлээр зарласан. Үүнийг төрөөс дэмжих хэрэгтэй.
- Цахилгаан станц, цахилгааны сүлжээ, төмөр зам зэрэг томоохон бүтээн байгуулалтын санхүүжилтийг арилжааны банкууд өөр хоорондоо, эсвэл төртэй, компаниудтай хамтран бий болгож, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Монголбанк, Сангийн яаманд хариуцуулах.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

--oOo--

Хавсралт 1. Хөгжлийн бодлогын баримт бичиг хоорондын уялдаа



Хавсралт 2. Монгол улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ ба санхүүжилтийн эх үүсвэрийн харьцуулалт

Зорилго	Д/д	Зорилт, арга хэмжээ	Хөрөнгийн хэмжээ тодорхойгүй	Эх үүсвэр тодорхойгүй	Санхүүжилтийн эх үүсвэр		
					УТ/ ОНТ	ГЗТ	Бусад
Цар тахлыг даван туулах	1.1	8	3	3	2	3	
Хүний хөгжлийн бодлого	2.1	26	4	3	15	4	4
	2.2	2			1	1	
	2.3	25	7	7	15	2	1
	2.4	3	1	1	2		
	2.5	12	2	2	3	7	1
	2.6	7				7	
Эдийн засгийн бодлого	3.1	11	8	8	1	2	
	3.2	19	1	1	9	1	8
	3.3	12	2		8	4	2
	3.4	4			1	2	1
	3.5	13			4	7	4
	3.6	26	5	1	15	5	5
	3.7	6			5		1
Засаглалын бодлого	4.1	24	5	5	18		1
	4.2	6	2	2	4	3	
	4.3	20	3	2	16	2	
	4.4	1			1		
	4.5	3			3		
	4.6	5	1	1	4		
Ногоон хөгжил	5.1	18	2	2	12	1	3
УБ, бүс, орон нутгийн хөгжил	6.1	6	1		4	4	
	6.2	6			2	4	
НИЙТ		263	47	38	152	52	31
Эзлэх хувь			17.9	14.4	55.7	19.0	11.4